

“ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, СИСТЕМ АЖИЛЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ”-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ САНАЛЫН ТОМЪЁОЛОЛ

1. Журмын 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.21¹ дэх заалт нэмэх:

“7.21¹. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч рүү гүйлгээ дамжуулах тохиолдолд Монголбанкны зөвшөөрөлтэй клирингийн системээр дамжуулж, төлбөр тооцоог шууд оролцогчийн Монголбанканд дээрх дансаар гүйцэтгэнэ.”

2. Журмын 1 дүгээр зүйлийн 1.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.9. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, оролцогч хоорондын бага дүнтэй бодит цагийн гүйлгээ, багцын гүйлгээ болон картын гүйлгээг Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн хариуцан ажиллуулж байгаа Автомат клиринг хаус систем, Картын нэгдсэн сүлжээ эсвэл Монголбанкны зөвшөөрөл бүхий клирингийн системээр дамжуулах бөгөөд төлбөр тооцоог шууд оролцогчийн Монголбанканд дээрх дансаар гүйцэтгэнэ.”;

3. Журмын 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4. Зөвшөөрөлтэй этгээдийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон нөхцөлд төлбөр тооцооны болон клирингийн системийн оператор нь тухайн оролцогчийн гүйлгээг зогсооно.”;

4. Журмын 7 дугаар зүйлийн 7.19.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.19.2 Нийт хувьцааны 5 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага өөрчлөгдөх;”;

5. Журмын 7 дугаар зүйлийн 7.29 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.29. АТМ төхөөрөмж ашиглан бэлэн мөнгө авах, орлогын гүйлгээ хийх шимтгэл 500 (таван зуун) төгрөг, шилжүүлэг хийх гүйлгээний шимтгэл 300 (гурван зуун) төгрөг, дансны үлдэгдэл шалгах, сүүлийн 10 гүйлгээний хуулга авах гүйлгээний шимтгэл 100 (зуун) төгрөгөөс тус тус дээшгүй байхаар тогтоох ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.”;

6. Журмын 7 дугаар зүйлийн 7.30 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.30. ПОБ болон ПОС төхөөрөмж ашиглан 1,000,000 (нэг сая) төгрөг хүртэлх дүнтэй бэлэн мөнгө авахад шимтгэлийн хэмжээ нь 500 (таван зуун) төгрөгөөс дээшгүй байх ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.”;

7. Журмын 7 дугаар зүйлийн 7.35.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.35.5. Баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгө нь эргэлтэд гарсан нийт цахим мөнгөнөөс дутвал тухайн өдөрт багтаан нөхөх;”;

8. Журмын 10 дугаар зүйлийн 10.21 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.21. Банк нь мобайл болон интернет гүйлгээний тайланг “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 7, 8, 9, 10-т заасны дагуу, картаас бусад хэрэгсэл ашиглан банкны салбар дээр хийгдсэн гүйлгээний тоон мэдээг Хүснэгт 5-д заасны дагуу сар тутам гаргаж дараа сарын 10-ны өдрийн дотор Монголбанкны тайлангийн цахим системд оруулж, тайлангийн баталгааны маягтыг (Хавсралт 9) дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор Монголбанканд албан бичгээр ирүүлнэ.”;